

**БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2021.12.14

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	-МУ-ын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” -Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2021 он) -“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний аймгийн 2020-2023 оны төлөвлөгөө(Аймгийн Засаг даргын 2020.01.16-ны өдөр батлагдсан)
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн хөгжлийн сан
3	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	-Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс -Сумдын Засаг даргын Тамгын газар, -Сумдын Эрх зүйн хөтөч -Хууль хяналтын байгууллагууд 2021 он
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно. 1.2.3. Аймгийн хэмжээнд бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулах. 1.3.1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим санд орох эрх зүйн актын тоог нэмэгдүүлэх. 1.3.2. Аймгийн хэмжээнд иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг баталж бүртгүүлэн мөрдөх. 1.3.3. Сум, байгууллагын дарга нараас батлан гаргасан эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэх. 1.4.1. ХЗДХЯ-наас бэлтгэн ирүүлэх иргэдэд эрх зүйн мэдлэг олгоход чиглэсэн бодит кейст тулгуурласан богино хэмжээ(нэг цуврал нь 15-20 минут)-ний 6

		цуврал(энэ нь дотроо хүүхдэд зориулсан, залуучуудад зориулсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан төрөлтэй) теле сериал киног орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтэд түгээн хүргэх. 1.4.2. ХЗДХЯ-наас бэлтгэн ирүүлсэн иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан зайлшгүй мэдвэл зохих 15 хуулийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бүх төрийн байгууллага, LED tv, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан нийтэд түгээх. 1.4.4. Хүүхдэд зориулсан сурталчилгааг хүүхэд залуус олноор үйлчлүүлдэг үйлчилгээний байгууллагын зааланд байршуулж, сурталчлах. 1.4.5. Эрх зүйн мэдлэгт зориулсан хялбаршуулсан “Малчин танд” гарын авлагыг багийн Засаг дарга бүрт хүргэх. 1.5.3. Эрх зүйн албан бус сургалтыг дараахь хэлбэрээр явуулна. –эрх зүйн анхан шатны болон богино хугацааны сургалт –ахисан түвшний буюу мэргэшүүлэх /тусгайлсан/ сургалт –цахим сургалт –зайны сургалт 1.5.4. Бүх нийтийн эрх зүйн боловсролын сургалтыг сумын Насан туршийн боловсролын төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах. 1.6.1. Хууль зүйн туслалцааны өмгөөлөгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх. 1.6.3. Иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэд шаардлагатай үедээ оршин суугаа газраасаа хууль зүйн туслалцаа, зөвлөгөөг онлайнаар авах нөхцөл боломжийг бүрдүүлэх. 1.6.5. Хөдөө орон нутгийн иргэдэд өмгөөллийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж, өмгөөлөгч, өмгөөллийн байгууллагын нэр, утасны дугаар, мэргэшсэн чиглэл, байрлалын талаарх мэдээллийг хүргэх, тэдэнтэй шууд холбогдох боломжийг бий болгох. 1.7.4. Хөтөлбөрийн зорилтыг хангах хүрээнд эрх зүйн албан бус(иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн) сургалтын ажлын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, хийх шаардлагатай
--	--	--


			ажлын талаар санал солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. Зорилт 2. Бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ. 2.1.4. Сум бүрт 3-4 эрх зүйн хөтөч ажиллуулах. 2.1.5. Иргэний нийгмийн байгууллагуудаас эрх зүйн хөтөч бэлтгэн ажиллуулах. 2.1.6. Эрх зүйн хөтөчийг гарын авлагаар хангах. 2.2.1. Олон нийтэд зориулсан эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох цахим мэдээллийн сан бүхий и-хөтөч портал сайт, хууль зүйн асуудлаар зөвлөгөө авах 1800-1202 дугаарыг сурталчлан таниулж, иргэн бүрийг хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авах боломжоор хангах. 2.2.3. И-хөтөч портал цахим хуудсанд эрх зүйн сургалт, сурталчилгааны мэдээллийн цахим сан бий болгож, эрх зүйн хөтөч нар ашиглах боломжийг бүрдүүлэх(эрх зүйн сургалт, сурталчилгааны контент, цуврал хичээлүүд, богино хэмжээний шторкуудыг санд оруулах) 3.2.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, эрх зүйн хөтчөөр дамжуулан эрх зүйн сургалт, сурталчилгааны гарын авлага, видео хичээлийг хөдөө орон нутаг сум, багуудад тогтмол хүргэх. 3.5.2. Гудамж, байр, байгууллагын хэмжээнд “Аюулгүй орчин” бүсүүдийг бий болгох ажлыг эхлүүлж, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн санаачлагыг дэмжих, сайн дурын эргүүлийг дэмжих ажлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран зохион байгуулах. 3.8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцогсод, хамтран ажиллагсдыг урамшуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн шинэлэг санаачлагыг дэмжиж, олон нийтэд хүргэх, сурталчлах. 3.8.2. Эрх зүйн хөтөчийн ажиллах журам, гэрээний дагуу эрх зүйн хөтөч нарын ажлыг улирал бүр дүгнэн тайлагнана.			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	5.0 сая төгрөг			
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь	

		Багц	2021			-			-		
6	Төсөл, зорилт:	хөтөлбөрийн	Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.								
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:		1.2.3. Халдварт цар тахалтай холбогдуулан сумдын “Эрх зүйн хөтөч”-үүдийг чадавхжуулах эрх зүйн албан бус сургалтыг цахим хэлбэрээр аймгийн Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнт, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, аймгийн Насан туршийн боловсролын төв зэрэг мэргэжлийн 12 байгууллагатай хамтран 60 эрх зүйн   хөтөчүүдэд зохион байгуулж, “Эрх хөтөч”-үүд бүрэн хамрагдаж цахим сургалтыг үр боллоо гэж Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Эрх зүйн хөтөч нэгдсэн групп”, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс нээсэн “Дундговь Эрх зүйн хөтөч пэйж хуудас”, “Эрх зүйн хөтөч” чат зэрэг цахим хэрэгслээр сумдын Эрх зүйн хөтөч нарыг арга зүйн удирдлага, мэдээ мэдээллээр ханган ажиллаж цахим хурал, уулзалт, сургалтыг Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулж, эрх зүйн хөтөчүүдийг зөвлөмж, арга зүй, мэдээллээр ханган ажиллалаа. 100 хувь 1.3.1. Тайлант хугацаанд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт								





хөтөчүүдэд зохион байгуулж, “Эрх хөтөч”-үүд бүрэн хамрагдаж цахим сургалтыг үр боллоо гэж Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс

“Эрх зүйн хөтөч

	693 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс шинээр 35, нэмэлт, өөрчлөлт орсон 535 хууль, Засгийн газрын тогтоол 41, УИХ-ын тогтоол 59, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 9, Ерөнхийлөгчийн зарлиг 13-ийг тус тус бүртгэн санг баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна. Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт давхардсан тоогоор 8 хууль, тогтоомж, хүчингүй болж хасагдсан 109 зүйл заалтыг тухай бүр эрх зүйн ангилал хийж, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 135 иргэн, албан тушаалтанд үйлчилгээ үзүүллээ. 70 хувь 1.3.2. Тайлант хугацаанд Луус, Өлзийт, Дэлгэрцогт сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын батлан гаргасан “Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” 3 эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүллээ.  100 хувь 1.3.3. Сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа. 2021 онд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан 1298 эрх зүйн акт, сумдын төрийн байгууллагуудын дарга нараас батлан гаргасан 798 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан 709 тушаалыг хуваарийн дагуу хянаж, нийт 682 эрх зүйн актад гаргасан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.  100 хувь
--	---


		1.4.1. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” 3 сарын аяны хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэн ирүүлсэн Надад итгэ, Гэнэн Цогоо, Ариун эрхэм нандин, Дуудлага, Хүү, Чимээгүй хөрш зэрэг богино хэмжээний 6 киног www.dundgovi.gov.mn сайт, “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар” “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж хуудсуудаар хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулав. 100 хувь 1.4.2. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэн ирүүлсэн Ан амьтны, Ахмад настны, Байгаль орчны, Эрүүл мэндийн, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн, Хүүхэд хамгаалах, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Малын хулгайтай тэмцэх, Мэдээллийн ил тод байдлын, Соёлын өвийг хамгаалах, Ойн тухай зэрэг хуулиудаар бэлтгэсэн 14 шторк, Хууль, эрх зүйн хэлтсээс бэлтгэсэн Гэр бүл гэж юу вэ, Хүүхдийн тэтгэлэгийн ажиллагаа харандааны адал явдал зэргийг www.dundgovi.gov.mn сайт, “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж хуудсуудаар, сум, байгууллагуудын пэйж хуудас, сумдын Эрх зүйн хөтөчүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, 100 хувь 1.4.4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, аймгийн төвийн Сайнцагаан сумын ЕБС, цэцэрлэгүүдийн заал, танхимуудад хүүхдийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, гарын авлагуудыг байршуулан сурталчлах ажлыг зохион байгуулав.
--	--	--



		70 хувь 1.4.5. Иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулан бэлтгэсэн “Малчин танд” хялбаршуулсан гарын авлагыг багийн Засаг даргын тоогоор буюу 68 ширхэгийг картжуулан хүргүүлж, мөн аймгийн Төв номын санд 2 ширхэг, Эрх зүйн хөтөчүүдээ хамгийн сайн идэвхтэй ажиллуулсан Цагаандэлгэр сумын Насан туршийн боловсролын төвд 2 ширхэг нийт 72 ширхэгийг түгээж, аяны богцоор малчдад судлуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулсан. 70 хувь 1.5.3. Эрх зүйн анхан шатны сургалтыг сумдын Насан туршийн боловсролын багш нарт 12 төрлийн хууль тогтоомжоор тусгай төлөвлөгөөтэйгөөр зохион байгууллаа. -Ахисан түвшний буюу мэргэшүүлэх сургалтыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга буюу “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч нарыг чадавхжуулах сургалтыг 2 төрлийн хууль тогтоомжоор зохион байгуулав. -Аюулаас сэргийлэх цогцолбор FM-107.5-аар улирал бүр сумдтай холбогдож зайны болон цахим сургалтыг бэлтгэгдсэн “Эрх зүйн хөтөч” нарт тус тус зохион байгуулсан. 100 хувь 1.5.4. Иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох зорилготой сумдын Эрх зүйн хөтөчүүд болон Насан туршийн боловсролын багш нартай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлэн тэдгээрийг хууль, эрх зүйн гарын авлага, хичээлийн сэдвүүдээр хангаж ажиллалаа. 70 хувь
--	--	--




1.6.1. Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч Г.Лхамын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилготой жил бүр



Хуульчийн багц сургалтад бүрэн хамруулж кредит цагийг тооцуулж хэвшүүлсэн. Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч эрүүгийн 40 хэргийн төлбөрийн чадваргүй 49 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 275 иргэнд үзүүллээ.

100 хувь

1.6.3. Хууль зүйн Луужин, И-хөтөч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Эрх зүйн хөтөч нэгдсэн групп”, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж хуудсууд нээгдсэнээр иргэд оршин суугаа газраасаа үл хамааран эрх зүйн анхан шатны зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээг онлайнаар авах нөхцлийг бүрдүүллээ. Эрх зүйн хөтчийн нэгдсэн группт аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүд нэгдэж тус группт тавигдсан хууль, эрх зүйн сурталчилгааны мэдээ, мэдээлэл, 1800-1202 подкастын цуврал дугааруудыг тухай бүрт нь Эрх зүйн хөтөчүүд шэйрлэж олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав.



100 хувь

1.6.5. Тус аймагт ажиллаж буй 9 өмгөөлөгчийн утас, албан ажлын хаяг зэргээр гарын авлага бэлтгэн 2020 онд 850 ширхэг, 2021 онд аймагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдын “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг 300 ш, иргэдэд нэн шаардлагатай хууль тогтоомжоор 300 ш гарын авлагыг тус тус бэлтгэн сумдад нийт 600 ширхэгийг 15 сумын

иргэдэд түгээн тарааж, тэдэнтэй холбогдох боломж нөхцлийг бүрдүүлснээс гадна www.e-khutuch.mn цахим хуудсанд өмгөөлөгч нарын мэдээллийг дэлгэрэнгүй хэлбэрээр байршуулсан.

ЭРДЭНЭДАЛАЙ СУМАНД БЭЛТГЭГДСЭН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧНҮД

№	Огноо	Нэр	Ажил-хүрээ	Утасны
1	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
2	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
3	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
4	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811

АЙМАГ ДАХЬ ӨМГӨӨЛӨГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Нэр	Ажил-хүрээ	Утасны
1	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
2	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
3	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811
4	10/10/2021	Батбаяр	Хувь, өмч хэд, СЭХ, хуульч	98118811

WWW.E-KHUTUCH.MN ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧНӨД ХУУЛЬ, ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

ХУУЛЬ, ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

ХУУЛЬ, ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

ХУУЛЬ, ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

ХУУЛЬ, ЦАХИМ ХУУДАС АЖИЛГУУЛСНААР ИРГЭНД

100 хувь

1.7.4. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 15 суманд бэлтгэгдсэн 60 “Эрх зүйн хөтөч” нарыг оролцуулан цахим уулзалтыг зохион байгуулж, өнөөгийн нөхцөл байдлын талаар санал солилцож, иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулах, хууль зүйн чиглэлийн тогтсон сувгуудыг бий болгон ашиглаж “Дундговь Эрх зүйн хөтөч” цахим хуудсаар эрх зүйн хөтөчүүдээс иргэд, олон нийтэд зохион байгуулах сурталчилгааны хуваарийн дагуу сумд 7, 7 хоногоор иргэд, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх арга зүй, удирдлагаар ханган хамтран ажиллалаа.

БАТЛАВ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧНИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОЛГОХ

ТУВАЛДГАЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧНИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОЛГОХ

2021 онд Хууль, Эрх зүйн хөтөч

“Дундговь Эрх зүйн хөтөч” ЦАХИМ ХУУДСААР ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧНҮДЭЭС ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРТАЛЧИЛГААНЫ ХУВААРЬ

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх” арга хэмжээний аймгийн төлөвлөгөөний 1.4.1, 1.4.2, 1.5.3, 1.5.4, 3.2.2 дүгээр заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд, иргэдэд эрх зүйн хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу “Дундговь Эрх зүйн хөтөч” группээр иргэд, олон нийтэд хууль, эрх зүйн сурталчилгаа зохион байгуулан түгээн дэлгэрүүлнэ. Үүнт:

№	Сумын нэр	Огноо, хугацаа	Дуусах хугацаа
1	Асхадий сумын ЗДТГ	2021.09.27	2021.10.01
2	Баянгол сумын ЗДТГ	2021.10.04	2021.10.08
3	Говь-Утгаал сумын ЗДТГ	2021.10.11	2021.10.15
4	Гурвансайхан сумын ЗДТГ	2021.10.18	2021.10.22
5	Дэлгэрхангай сумын ЗДТГ	2021.10.25	2021.10.29
6	Дэлгэрцогт сумын ЗДТГ	2021.11.01	2021.11.05
7	Даран сумын ЗДТГ	2021.11.08	2021.11.12
8	Нүүс сумын ЗДТГ	2021.11.15	2021.11.19

100 хувь

2-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн 1:

2.1.4. “Эрх зүйн хөтөч бэлтгэх” сургалтын төслийг боловсруулан батлуулж, Орон нутгийн хөгжлийн сангаас 2019 онд 10,0 сая төгрөгийг шийдвэрлүүлж, сум бүрт 3-4 эрх зүйн хөтөчийг бэлтгэсэн. Жил бүр бэлтгэсэн эрх зүйн хөтөчүүдийг танхимаар болон цахим хэлбэрээр давтан сургаж чадавхжуулах ажлыг зохион байгуулж байна.



100 хувь

2.1.5. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй “Оюуны гэгээ” Төрийн бус байгууллагаас 2 эрх зүйн хөтөчийг бэлтгэн, уг 2 хөтөчийг 3 төрлийн гарын авлага ном

	товхимолоор ханган чадавхжуулж хамтран ажиллаж байна. 100 хувь 2.1.6. Эрх зүйн хөтөч бүртэй сумдын ЗДТГ-ын дарга 2019 оны 9 дүгээр сараас эхлэн Эрх зүйн хөтөчийн ажиллах гэрээг байгуулан, хагас, бүтэн жилээр үйл ажиллагааг дүгнэж, Эрх зүйн хөтөч бүрийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс өгсөн “Эрх зүйн хөтчийн гарын авлага”, “Эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга бэлтгэх, түгээх, ажлын нэгдсэн арга зүй, шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлал”, “Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтын хөтөлбөр” зэрэг 3 төрлийн гарын авлага, www.e-khutuch.mn цахим сангийн танилцуулга, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн танилцуулга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан сургалтын гарын авлага DVD, Хууль зүйн Луужин пэйж хуудасны танилцуулга, www.e-khutuch.mn цахим хуудасны танилцуулга зэрэг гарын авлагаар хангасан.  100 хувь 2.2.1. Эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох цахим мэдээллийн сан бүхий и-хөтөч сайт, хууль зүйн асуудлаар зөвлөгөө авах 1800-1202 дугаарын сурталчилгаа, Эрх зүйн хөтөч нэгдсэн группт тавигдсан 1800-1202 подкастын цуврал дугааруудыг тухай бүрт нь Эрх зүйн хөтөчүүд шэйрлэн бүх сумдын иргэд, олон нийтэд түгээж, дээрх дугаар, сайтаас зөвлөгөө авахад туслан ажиллаж байна. 70 хувь 2.2.3. Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж системчлэл, лавлагаа, хүний эрх, ГХУС ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод www.e-khutuch.mn цахим хуудсыг орон нутагт хариуцан ажиллах чиг үүргийг тусган ажиллуулж байна. И-хөтөч портал цахим хуудсанд эрх зүйн сургалт, сурталчилгааны мэдээллийн цахим сан бий болгож, эрх зүйн хөтөч нар үйл ажиллагаандаа ашиглаж байна. 70 хувь 3.2.2. Нэн шаардлагатай хууль тогтоомжоор бэлтгэсэн 14ш шторк, богино хэмжээний 6 кино, ШШГГ-тай хамтран Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, “Хүүхдийн тэтгэлэг” харандааны адал явдал шторкууд, орон нутагт ажиллаж буй өмгөөлөгч, Эрх зүйн хөтөчүүдийн дэлгэрэнгүй
--	--

	танилцуулгыг 300ш, нэн шаардлагатай хууль тогтоомжоор 300ш гарын авлагуудыг Эрх зүйн хөтөч нарт хүргүүлж, тэднээс сум, багуудад олшруулан түгээх ажлыг зохион байгуулсан. 100 хувь 3.5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйл буюу аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд 2021 онд 146.500 сая төгрөг батлуулж, хууль сахиулах байгууллагуудын саналд үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн нэгдүгээр хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 44 заалттайгаар батлуулан 93 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа. -Олон нийтийн цагдаа цалин урамшуулалд-28.312.750 сая төгрөг буюу 19.33 хувь, сургалт зөвлөгөөн, сурталчилгаа-46.668.590 сая төгрөг буюу 31.86 хувь, сум байгууллага, шагнал урамшуулал-24.557.460 сая төгрөг буюу 16.77 хувь, тоног төхөөрөмж дэмжлэг-23.593.700 сая төгрөг буюу 16.11 хувь, сумын ГХУССЗ дэмжлэг-23.367.500 сая төгрөг буюу 15.95 хувь байгаа нийт санхүүжилтийн 50 гаруй хувь нь олон нийтийн цагдаагийн урамшуулал, сургалт, зөвлөгөөн сурталчилгааны ажилд зарцуулагдсан байна. 100 хувь 3.8.1.Сумдад ажиллаж буй Эрх зүйн хөтөчүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” 3 сарын аяныг зохион байгуулан, аймаг, сумын цахим хуудсуудаар дамжуулан иргэн бүрт эрх зүйн боловсрол олгохоор хамгийн идэвхтэй ажиллаж буй Луус сумын Эрх зүйн хөтөч Г.Цолмонгийн мэдээ, мэдээлэл, подкаст, шторкуудыг “Дундговь Эрх зүйн хөтөч” группээр сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. 70% 3.8.2. Эрх зүйн хөтөчийн ажиллах журмын дагуу эрх зүйн хөтөч нарын ажлыг хагас, бүтэн жилээр сумын ЗДТГ-ын дарга нар дүгнэж, жилийн эцсээр нэгтгэсэн дүнг Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлэн тайлагнаж байна. 100%	
--	---	---

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		-Эрх зүйн албан ба албан бус сургалтыг Төрийн болон төрийн бус байгууллага, хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. -“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум бүрт 3-4 эрх зүйн хөтөчийг бэлтгэн, аймгийн хэмжээнд нийт 60 эрх зүйн хөтөчтэй болсон. -Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс бэлтгэн ирүүлсэн ном товхимол, шторк, кино, подкаст зэрэг гарын авлагыг түгээн дэлгэрүүлж, хэрэгжилтэнд судалгаагаар хяналт тавьж ажилласан. -“Эрх зүйн хөтөч” бэлтгэх, иргэд олон нийтэд эрх зүйн албан ба албан бус сургалтыг зохион байгуулахад хөрөнгө санхүү, хүн хүчний нөөцийг бэлтгэх төсөв, хөрөнгийг улсын хэмжээнд төсөвт тусгайлан төсөвлөж, хамтран ажиллах.		
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд иргэн бүрт хүрч ажиллахад дэмжлэг туслалцаа үзүүлж, эрх зүйн хөтөчүүдийг давтан сургах ажлыг улсын хэмжээнд ХЗДХЯ хариуцан шийдвэрлэх.		
9	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо		65		
10	Бүх шатны төрийн байгууллагад хамаарах				
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		90.7	2/23	1/14	2/9
11	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ		Нэгдсэн үнэлгээ		
				91.4%	90.7%

ТАЙЛАН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.ЦЭНГЭЛМАА/

ТАЙЛАН ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Л.БАЯРСАЙХАН/